



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/492

Хэрлэн сум

Хонины цэцэг өвчинөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны А/205 тушаалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галшар, Баянхутаг, Батноров, Баян-Овоо, Хэрлэн сумын хонь, хургыг хонины цэцэг өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг 2022 оны 9 дүгээр сарын 26-аас 15 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын маршрут зураглал гаргах, малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, тарилгын бүрэлдэхүүнд багийн Засаг нарыг оролцуулж, хүн хүчээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж, ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т даалгасугай

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, тасгийн улсын байцаагч нарт хариуцуулсугай.

5. Дархлаажуулалтын гүйцэтгэл, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

